

## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭ (2024 оны IV улирал)

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар манай улсын нийт 15 ба түүнээс дээш насны хүн амын 62.2 (1.4 сая) хувь нь ажиллах хүч, 37.8 (869.2 мянга) хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Мөн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсөж, өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурсан байна. Нийт 1.4 сая ажиллах хүчний 94.9 (1.3 сая) хувийг ажиллагч, 5.3 (75.4 мянга) хувийг ажилгүй иргэн бүрдүүлж байна. Харин ажиллах хүчнээс гадуурх 869.2 мянган хүн байгаагийн 1.3 (10.9 мянга) хувь нь боломжит ажиллах хүч буюу ажил хийх хүсэлтэй ч тодорхой шалтгаанаар ажил хайгаагүй эсвэл шууд ажил хийх боломжгүй байсан хүн ам байна.<sup>1</sup>

Ажиллагчдын тоо 2024 оны IV улиралд 1,353.4 мянга болж өмнөх оны мөн үеэс 31.0 мянгаар, өмнөх улирлаас 6.9 мянгаар өссөн байна. Ажиллагчдыг эдийн засгийн үндсэн салбараар авч үзвэл, 2024 оны 4-р улирлын байдлаар нийт ажиллагчдын 54.2 (733.9 мянга) хувь нь үйлчилгээний салбарт, 23.7 (321.3 мянга) хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 22.0 (298.2 мянга) хувь нь аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар харвал, нийт ажиллагчдын 14.1 (190.6 мянга) хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт, 9.6 (130.0 мянга) хувь нь боловсролын салбарт, 7.5 (101.3 мянга) нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 7.1 (96.1 мянга) хувь нь барилгын салбарт, 7.0 (94.5 мянга) хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байгаа ба эдгээр нь хөдөө аж ахуйн салбараас бусад хамгийн олон ажиллагчтай салбарууд юм.

Ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 23.3 (314.6 мянга), мэргэжилтэн 18.1 (244.9 мянга), худалдаа үйлчилгээний ажилтан 15.7 (212.6 мянга), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 10.2 (138.6 мянга), машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч 10.0 (135.3 мянга), энгийн ажил, мэргэжлийн ажилтан 7.8 (105.1 мянга), менежер 7.1 (96.4 мянга), бусад төрлийн ажил мэргэжлийн ажилтан 7.8 (105.9 мянга) хувийг тус тус эзэлж байна.


Ажиллагчдын 606.5 мянга (44.8 хувь) нь Улаанбаатар хотод, 746.8 мянга (55.2 хувь) нь хөдөө, орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 261.3 мянга (19.3 хувь) нь Хангайн бүсэд, 203.1 мянга (15.0 хувь) нь Төвийн бүсэд, 181.3 мянга (13.4 хувь) нь Баруун бүсэд, 101.2 мянга (7.5 хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 39.2 мянгаар (6.9 хувь), Хангайн бүс 2.9 мянгаар (1.1 хувь), Зүүн бүс 2.2 мянгаар (2.2

---

<sup>1</sup> Үндэсний статистикийн хороо [www.1212.mn](http://www.1212.mn)

хувь) өссөн бол Төвийн бүс 10.5 мянгаар (4.9 хувь), Баруун бүс 2.8 мянгаар (1.5 хувь) буурсан байна.

Зураг 1: Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн




Хүснэгт 1: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд (2021-2024)<sup>2</sup>

| Үзүүлэлт                                                                       | 2021 он  | 2022 он  | 2023 он  | 2024 оны IV улирал |
|--------------------------------------------------------------------------------|----------|----------|----------|--------------------|
| 15 ба түүнээс дээш насны хүн ам /мян.хүн/                                      | 2,227.6  | 2,272.5  | 2,297.7  | 2,297.9            |
| Ажиллах хүч /мян.хүн/                                                          | 1,317.4  | 1,370.6  | 1,367.3  | 1,428.7            |
| Ажиллагчид /мян.хүн/                                                           | 1,208.0  | 1,283.1  | 1,294.7  | 1,353.4            |
| Ажилгүй иргэд /мян.хүн/                                                        | 109.4    | 87.5     | 72.5     | 75.3               |
| Ажиллах хүчнээс гадуурх хүн ам /мян.хүн/                                       | 910.2    | 901.9    | 930.4    | 869.2              |
| Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/                                         | 59.1     | 60.3     | 59.5     | 62.2               |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувь/                                              | 54.2     | 56.5     | 56.3     | 58.9               |
| Ажилгүйдлийн түвшин /хувь/                                                     | 8.3      | 6.4      | 5.3      | 5.3                |
| Ядуурлын түвшин /хувь/                                                         | -        | 21.6     | -        | -                  |
| Ажил хайгч иргэний тоо /мян.хүн/                                               | 27,950   | 21,257   | 11,662   | 11,970             |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд /мян.хүн/                                             | 18,644   | 13,966   | 8,813    | 9,996              |
| Ажлын байрны захиалгын тоо                                                     | 51,034   | 52,211   | 84,870   | 112,390            |
| Ажилд зуучлагдсан иргэний тоо                                                  | 29,929   | 32,290   | 35,281   | 33,485             |
| Шинэ ажлын байранд орсон иргэний тоо                                           | 28,390   | 27,390   | 36,138   | 31,882             |
| ХЭДС-с зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/                                         | 87,217.0 | 73,861.7 | 62,356.6 | 68,771.6           |
| ХЭДС-ийн жижиг зээлд зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/                           | 11,645.0 | -        | 21,668.9 | 13,000.0           |
| ХЭДС-ийн гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого /сая.төгрөг/            | 40,707.3 | 40,841.1 | 86,920.9 | 124,928.7          |
| ХЭД үйлчилгээ арга хэмжээнд хамрагдсан хүн                                     | 39,807   | 85,287   | 58,086   | 166,917            |
| ХЭДС-ийн хүрээнд бий болсон ажлын байрны тоо                                   | 22,988   | 42,813   | 41,678   | 67,917             |
| Гадаадад ажиллах хүч илгээх үйлчилгээ авсан иргэний тоо                        | 49,449   | 35,769   | 29,140   | 30,717             |
| Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо | 4,039    | 10,850   | 19,611   | 8,024              |
| БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр илгээсэн Монгол иргэний тоо                       | 176      | 863      | 846      | 722                |
| Япон Улсад ажиллахаар хил нэвтэрсэн ур чадвартай ажилтан /ХХҮЕГ/               | -        | 137      | 59       | 170                |

<sup>2</sup> Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Зураг 2: Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



а) Ажилгүй хүн, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар хувиар



б) Боломжит ажиллах хүч, хөдөлмөр эрхлээгүй шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



Ажилгүйдлийн шалтгааныг задалж харвал, нийт 75.4 мянган ажилгүй хүн байгаагийн дийлэнх нь буюу 33.0 хувь нь ажил хайгаад олдохгүй байгаа, 10.0 хувь нь мэргэжил, дадлага туршлага байхгүй, 9.9 хувь нь мэргэжилд тохирох ажил байхгүй шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна. Харин боломжит ажиллах хүч 10.9 мянга байгаагийн 20.1 хувь нь жирэмсэн, хүүхэд асарсан, 12.0 хувь нь өвчтэй, 11.2 хувь нь бусдыг асарсан шалтгаанаар хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоогүй байна.

Нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилгоор жил бүр хийгддэг Барометрийн судалгааны үр дүнгээс харахад, өнгөрөгч онд аж ахуй нэгж байгууллагын 5.5 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтныг авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн нь өмнөх оны мөн дүнгээс 18.1 пунктээр буурсан үзүүлэлт болжээ. Ажиллах хүчний хомсдолыг тархааж үзвэл дээрх ажил олгогчдод

жилийн хугацаанд 16.2 мянган ажиллах хүчний хомсдол үүссэн нь өмнөх оноос буурсан байна. Энэ нь бөөний болон жижиглэн худалдаа үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад илүүтэй тохиолдож хамгийн их хувийг эзэлж байна.

Хөдөлмөрийн зах зээл дээрх энэ зөрүү нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь ажилгүй иргэдэд хүрч, илүү олон хүнийг хамруулдаг, ажил хайгч болон ажил олгогчдын аль алиных нь эрэлт, хэрэгцээнд нийцэж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна<sup>3</sup>. Мөн хөдөлмөрийн зах зээл дээрх ажилд зуучлах, ажлын байртай холбох үйлчилгээг хэрхэн хурдан, үр ашигтай болгох талаар бодит арга хэмжээ авах нь маш чухал бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чанарыг сайжруулснаар хөдөлмөрийн зах зээл дээрх ажилгүйдлийг бууруулах, ажилгүйдэл үргэлжлэх хугацааг багасгах, ур чадварын тохирлыг сайжруулах боломжтой юм<sup>4</sup>.

### АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

**Ажил хайгч иргэн:** 2024 оны 12 дугаар сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо 11,970 болж өмнөх сараас 1,458 хүнээр буюу 12,1 хувиар өссөн ба өмнөх оны мөн үеэс 308 хүнээр буюу 2,5 хувиар өссөн байна.



### Ажил хайгч иргэдийг байршилаар харуулвал

|               | Ажил хайгч | Үүнээс эмэгтэй |
|---------------|------------|----------------|
| 1 Баруун бүс  | 3536       | 1857           |
| 2 Баян-Өлгий  | 1150       | 597            |
| 3 Говь-Алтай  | 595        | 324            |
| 4 Завхан      | 384        | 199            |
| 5 Увс         | 595        | 313            |
| 6 Ховд        | 812        | 424            |
| 7 Хангайн бүс | 2869       | 1391           |
| 8 Архангай    | 623        | 325            |


<sup>3</sup> Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ: Эдийн засгийг сэргээх, төрөлжүүлэх зорилгоор илүү хүртээмжтэй Хөдөлмөрийн зах зээлийг бий болгох нь - Нэгтгэл Тайлан Дэлхийн банк, ХНХЯ, ЭЗХЯ, 2022 он

<sup>4</sup> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ ЕХ, НҮБХХ, НҮБ-ын ХХААБ - 2022


|    |                    |              |             |
|----|--------------------|--------------|-------------|
| 9  | Баянхонгор         | 824          | 389         |
| 10 | Булган             | 217          | 111         |
| 11 | Орхон              | 588          | 240         |
| 12 | Өвөрхангай         | 373          | 188         |
| 13 | Хөвсгөл            | 244          | 138         |
| 14 | <b>Төвийн бүс</b>  | <b>1550</b>  | <b>750</b>  |
| 15 | Говьсүмбэр         | 27           | 4           |
| 16 | Дархан-Уул         | 253          | 129         |
| 17 | Дорноговь          | 175          | 85          |
| 18 | Дундговь           | 257          | 125         |
| 19 | Өмнөговь           | 206          | 117         |
| 20 | Сэлэнгэ            | 350          | 161         |
| 21 | Төв                | 282          | 129         |
| 22 | <b>Зүүн бүс</b>    | <b>1089</b>  | <b>649</b>  |
| 23 | Дорнод             | 422          | 258         |
| 24 | Сүхбаатар          | 264          | 191         |
| 25 | Хэнтий             | 403          | 200         |
| 26 | <b>Улаанбаатар</b> | <b>2926</b>  | <b>1339</b> |
| 27 | Хан-Уул            | 305          | 119         |
| 28 | Багануур           | 170          | 87          |
| 29 | Баянзүрх           | 359          | 157         |
| 30 | Налайх             | 268          | 141         |
| 31 | Баянгол            | 289          | 127         |
| 32 | Сүхбаатар          | 144          | 60          |
| 33 | Чингэлтэй          | 266          | 114         |
| 34 | Багахангай         | 51           | 21          |
| 35 | Сонгинохайрхан     | 1074         | 513         |
| 36 | <b>УЛСЫН ДҮН</b>   | <b>11970</b> | <b>5986</b> |

Нийт ажил хайгч иргэдийн 3536 буюу 29,5 хувь нь Баруун бүсэд, 2869 буюу 24 хувь нь Хангайн бүсэд, 1550 буюу 12,9 хувь нь Төвийн бүсэд, 1089 буюу 9,1 хувь нь Зүүн бүсэд, 2926 буюу 24,4 хувь нь Улаанбаатарт байна.

#### **Ажил хайгч иргэд: насаар, хүйсээр**



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр авч үзвэл 14,7 хувь буюу 1763 нь 15-24 насны, 32,0 хувь буюу 3826 нь 25-34 насны, 29,4 хувь буюу 3525 нь 35-44 насны, 17,9 хувь буюу 2148 нь 45-54 насны, 3,9 хувь буюу 466 нь 55-59 насны, 2,0 хувь буюу 242 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



### **Ажил хайгч иргэд: боловсролоор**

Нийт ажил хайгч иргэдийн 213 буюу 1,8 хувь нь магистр, доктор, 3279 буюу 27,4 хувь нь дипломын болон бакалаврын, 528 буюу 4,4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 900 буюу 7,5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5385 буюу 45,0 хувь нь бүрэн дунд, 1052 буюу 8,8 хувь нь суурь, 484 буюу 4,0 хувь нь бага, 129 буюу 1,1 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.



### **Бүртгэлтэй ажилгүй иргэд**

2024 оны 12 дугаар сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 9996 болж өмнөх сараас 1336 хүнээр буюу 13,8 хувиар өссөн ба өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: өмнөх оны мөн үеэс 1183 хүнээр буюу 11,8 хувиар өссөн байна.



**Бүртгэлтэй ажилгүй иргэд бүсээр байршилаар**

| №  | Аймаг, дүүрэг, байгууллагаар | Бүртгэлтэй ажилгүй иргэн | Үүнээс эмэгтэй |
|----|------------------------------|--------------------------|----------------|
|    | <b>Баруун бүс</b>            | <b>2911</b>              | <b>1481</b>    |
| 1  | Баян-Өлгий                   | 1113                     | 572            |
| 2  | Говь-Алтай                   | 540                      | 290            |
| 3  | Завхан                       | 336                      | 163            |
| 4  | Увс                          | 520                      | 267            |
| 5  | Ховд                         | 402                      | 189            |
|    | <b>Хангайн бүс</b>           | <b>2372</b>              | <b>1119</b>    |
| 6  | Архангай                     | 508                      | 247            |
| 7  | Баянхонгор                   | 742                      | 340            |
| 8  | Булган                       | 168                      | 84             |
| 9  | Орхон                        | 531                      | 216            |
| 10 | Өвөрхангай                   | 191                      | 102            |
| 11 | Хөвсгөл                      | 232                      | 130            |
|    | <b>Төвийн бүс</b>            | <b>1216</b>              | <b>590</b>     |
| 12 | Говьсүмбэр                   | 21                       | 3              |
| 13 | Дархан-Уул                   | 185                      | 94             |
| 14 | Дорноговь                    | 144                      | 73             |
| 15 | Дундговь                     | 212                      | 107            |
| 16 | Өмнөговь                     | 173                      | 100            |
| 17 | Сэлэнгэ                      | 251                      | 114            |
| 18 | Төв                          | 230                      | 99             |
|    | <b>Зүүн бүс</b>              | <b>947</b>               | <b>556</b>     |
| 19 | Дорнод                       | 388                      | 242            |
| 20 | Сүхбаатар                    | 185                      | 133            |
| 21 | Хэнтий                       | 374                      | 181            |
|    | <b>Улаанбаатар</b>           | <b>2550</b>              | <b>1159</b>    |
| 1  | Хан-Уул                      | 272                      | 105            |
| 2  | Багануур                     | 162                      | 84             |
| 9  | Баянзүрх                     | 312                      | 137            |
| 4  | Налайх                       | 206                      | 103            |
| 5  | Баянгол                      | 251                      | 111            |
| 6  | Сүхбаатар                    | 124                      | 55             |


|   |                  |             |             |
|---|------------------|-------------|-------------|
| 7 | Чингэлтэй        | 241         | 97          |
| 8 | Багахангай       | 24          | 9           |
| 9 | Сонгинохайрхан   | 958         | 458         |
|   | <b>УЛСЫН ДҮН</b> | <b>9996</b> | <b>4905</b> |

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2911 буюу 29,1 хувь нь Баруун бүсэд, 2372 буюу 23,7 хувь нь Хангайн бүсэд, 1216 буюу 12,2 хувь нь Төвийн бүсэд, 947 буюу 9,5 хувь нь Зүүн бүсэд, 2550 буюу 25,5 хувь нь Улаанбаатарт байна.



### **Бүртгэлтэй ажилгүй иргэд: насаар, хүйсээр**

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 14,6 хувь буюу 1459 нь 15-24 насны, 32,8 хувь буюу 3280 нь 25-34 насны, 29,4 хувь буюу 2942 нь 35-44 насны, 17,6 хувь буюу 1756 нь 45-54 насны, 3,7 хувь буюу 365 нь 55-59 насны, 1,9 хувь буюу 194 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.




### **Бүртгэлтэй ажилгүй иргэд: боловсролоор**

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 185 буюу 1,9 хувь нь магистр, доктор, 2823 буюу 28,2 хувь нь дипломын болон бакалаврын, 463 буюу 4,6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 763 буюу

7,6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4414 буюу 44,2 хувь нь бүрэн дунд, 822 буюу 8,2 хувь нь суурь, 419 буюу 4,2 хувь нь бага, 107 буюу 1,1 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4905 буюу 49,0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



## ХОЁР.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

### 2.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ:

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлсэн байдлыг 2024 оны 12 дугаар сарын байдлаар авч үзвэл:

- Зорилтот бүлгээр ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл авсан **20414** нийт иргэн, үүнээс эмэгтэй **11244** байна.
- Зорилтот бүлгээр бүлгийн сургалт, зөвлөгөөний хэлбэрээр ажил, үйлчилгээнд хамрагдсан **48826** иргэн, үүнээс эмэгтэй **24252** байна.
- Дээрх үйлчилгээнд хамрагдаж үйлчилгээ авсан байгууллагын тоо **1491**, үйлчилгээ авсан нийт иргэд **69240** үүнээс эмэгтэй 35496 байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөө авсан байдлыг байршилаар харуулвал:

| № | Аймаг, дүүрэг, байгууллагаар | Ганцаарчилсан зөвлөгөө авсан хүний тоо | Үүнээс эмэгтэй | Бүлгийн зөвлөгөө авсан хүний тоо | Үүнээс эмэгтэй |
|---|------------------------------|----------------------------------------|----------------|----------------------------------|----------------|
|   | <b>Баруун бүс-Дүн</b>        | <b>2663</b>                            | <b>1314</b>    | <b>5957</b>                      | <b>3159</b>    |
| 1 | Баян-Өлгий                   | 772                                    | 328            | 2223                             | 1236           |
| 2 | Говь-Алтай                   | 429                                    | 280            | 205                              | 76             |
| 3 | Завхан                       | 81                                     | 26             | 276                              | 121            |
| 4 | Увс                          | 701                                    | 304            | 1505                             | 779            |

|    |                        |              |              |              |              |
|----|------------------------|--------------|--------------|--------------|--------------|
| 5  | Ховд                   | 680          | 376          | 1748         | 947          |
|    | <b>Хангайн бүс-Дүн</b> | <b>2737</b>  | <b>1682</b>  | <b>7397</b>  | <b>3831</b>  |
| 6  | Архангай               | 312          | 176          | 1138         | 582          |
| 7  | Баянхонгор             | 796          | 489          | 1880         | 1005         |
| 8  | Булган                 | 317          | 202          | 238          | 114          |
| 9  | Орхон                  | 389          | 254          | 224          | 86           |
| 10 | Хөвсгөл                | 348          | 223          | 2626         | 1306         |
| 11 | Өвөрхангай             | 575          | 338          | 1291         | 738          |
|    | <b>Төвийн бүс-Дүн</b>  | <b>3509</b>  | <b>1931</b>  | <b>6922</b>  | <b>3330</b>  |
| 12 | Говьсүмбэр             | 94           | 59           | 353          | 166          |
| 13 | Дархан-Уул             | 872          | 492          | 1582         | 754          |
| 14 | Дорноговь              | 419          | 239          | 1142         | 589          |
| 15 | Дундговь               | 990          | 536          | 385          | 195          |
| 16 | Сэлэнгэ                | 421          | 187          | 460          | 193          |
| 17 | Төв                    | 588          | 353          | 1634         | 767          |
| 18 | Өмнөговь               | 125          | 65           | 1366         | 666          |
|    | <b>Зүүн бүс-Дүн</b>    | <b>1501</b>  | <b>707</b>   | <b>2581</b>  | <b>1315</b>  |
| 19 | Дорнод                 | 463          | 164          | 878          | 480          |
| 20 | Сүхбаатар              | 102          | 59           | 148          | 65           |
| 21 | Хэнтий                 | 936          | 484          | 1555         | 770          |
|    | <b>Улаанбаатар</b>     | <b>10003</b> | <b>5611</b>  | <b>25969</b> | <b>12617</b> |
| 1  | Багануур               | 1444         | 865          | 3710         | 1761         |
| 2  | Багахангай             | 526          | 312          | 931          | 481          |
| 9  | Баянгол                | 1506         | 879          | 6986         | 3456         |
| 4  | Баянзүрх               | 580          | 297          | 273          | 121          |
| 5  | Налайх                 | 1136         | 638          | 4514         | 2286         |
| 6  | Сонгинохайрхан         | 1315         | 714          | 2336         | 1106         |
| 7  | Сүхбаатар              | 1066         | 593          | 1996         | 968          |
| 8  | Хан-Уул                | 124          | 82           | 227          | 106          |
| 9  | Чингэлтэй              | 2306         | 1231         | 4996         | 2332         |
|    | <b>УЛСЫН ДҮН</b>       | <b>20413</b> | <b>11245</b> | <b>48826</b> | <b>24252</b> |


## **2.2 Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга:**

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.


Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг, нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 11,8 хувьтай байхад нийслэлд 5,1 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 8,8 хувьтай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тооцов.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулвал:



2024 оны 12 дугаар сард ажил олгогчдоос нийт 112,390 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 27,520 буюу 24,4 хувиар өссөн байна.



Ажлын байрны захиалгыг байршилаар харуулвал

| №  | Аймаг              | Тоо          |
|----|--------------------|--------------|
|    | <b>Баруун бүс</b>  | <b>8015</b>  |
| 1  | Баян-Өлгий         | 994          |
| 2  | Говь-Алтай         | 1753         |
| 3  | Завхан             | 618          |
| 4  | Увс                | 2132         |
| 5  | Ховд               | 2518         |
|    | <b>Хангайн бүс</b> | <b>21523</b> |
| 6  | Архангай           | 5337         |
| 7  | Баянхонгор         | 2805         |
| 8  | Булган             | 2678         |
| 9  | Орхон              | 2998         |
| 10 | Өвөрхангай         | 892          |
| 11 | Хөвсгөл            | 6813         |
|    | <b>Төвийн бүс</b>  | <b>20430</b> |
| 12 | Говьсүмбэр         | 885          |
| 13 | Дархан-Уул         | 3037         |
| 14 | Дорноговь          | 3219         |
| 15 | Дундговь           | 3018         |
| 16 | Өмнөговь           | 4892         |

|    |                    |                |
|----|--------------------|----------------|
| 17 | Сэлэнгэ            | 3001           |
| 18 | Төв                | 2378           |
|    | <b>Зүүн бүс</b>    | <b>12771</b>   |
| 19 | Дорнод             | 3699           |
| 20 | Сүхбаатар          | 4854           |
| 21 | Хэнтий             | 4218           |
|    | <b>Улаанбаатар</b> | <b>49651</b>   |
| 1  | Хан-Уул            | 9277           |
| 2  | Багануур           | 1038           |
| 9  | Баянзүрх           | 10636          |
| 4  | Налайх             | 2018           |
| 5  | Баянгол            | 5677           |
| 6  | Сүхбаатар          | 7820           |
| 7  | Чингэлтэй          | 4305           |
| 8  | Багахангай         | 664            |
| 9  | Сонгинохайрхан     | 8216           |
|    | <b>УЛСЫН ДҮН</b>   | <b>112,390</b> |

*Ажлын байрны захиалгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар 2024 оны 12 дугаар сарын байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.*


| №          | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал           | Ажлын байрны захиалгын тоо | Эзлэх хувь /%/ |
|------------|----------------------------------------------------------|----------------------------|----------------|
| 1          | Хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуур                   | 16599                      | 14.9           |
| 2          | Уул уурхай олборлолт                                     | 13804                      | 12.3           |
| 3          | Боловсруулах үйлдвэр                                     | 16549                      | 14.7           |
| 4          | Цахилгаан, хий, уур агааржуулалт                         | 441                        | 0.4            |
| 5          | Усны хангамж бохир ус зайлуулах систем хог хаягдал       | 8954                       | 8.0            |
| 6          | Барилга                                                  | 11516                      | 10.2           |
| 7          | Бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ                | 8240                       | 7.3            |
| 8          | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа                        | 3006                       | 2.7            |
| 9          | Зочид буудал, зоогийн газар                              | 3558                       | 3.2            |
| 10         | Мэдээлэл холбоо                                          | 586                        | 0.5            |
| 11         | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа                 | 582                        | 0.5            |
| 12         | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа                        | 36                         | 0.0            |
| 13         | Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа   | 831                        | 0.7            |
| 14         | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа           | 6311                       | 5.6            |
| 15         | Төрийн удирдлага болон батлан хамгаалах үйл ажиллагаа    | 8556                       | 7.6            |
| 16         | Боловсрол                                                | 6121                       | 5.4            |
| 17         | Эрүүл мэнд, нийгмийн халамж                              | 3115                       | 2.8            |
| 18         | Урлаг үзвэр тоглоом наадам                               | 541                        | 0.5            |
| 19         | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа                         | 2759                       | 2.5            |
| 20         | Хүн хөлслөн ажиллуулдаг, өрхийн аж ахуй                  | 247                        | 0.2            |
| 21         | Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 38                         | 0.0            |
| <b>ДҮН</b> |                                                          | <b>112,390</b>             | <b>100</b>     |

Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна.

| №   | Ажил мэргэжлийн ангилал                                              | Ажлын байрны захиалгын тоо | Эзлэх хувь /%/ |
|-----|----------------------------------------------------------------------|----------------------------|----------------|
| 1   | Менежер                                                              | 3,838                      | 3.4            |
| 2   | Мэргэжилтэн                                                          | 20,688                     | 18.4           |
| 3   | Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/                               | 7,643                      | 6.8            |
| 4   | Контор үйлчилгээний ажилтан                                          | 2,088                      | 1.9            |
| 5   | Худалдаа үйлчилгээний ажилтан                                        | 11,561                     | 10.3           |
| 6   | ХАА, загас ан агнуурын ажилтан                                       | 8,177                      | 7.3            |
| 7   | Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан | 15,787                     | 14.0           |
| 8   | Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч                | 8,982                      | 8.0            |
| 9   | Зэвсэгт хүчний ажил, мэргэжил                                        | 2,667                      | 2.4            |
| 10  | Энгийн ажил, мэргэжил                                                | 30,959                     | 27.5           |
| ДҮН |                                                                      | <b>112,390</b>             | <b>100</b>     |

### 2.3 Ажилд зуучлах үйлчилгээ:

2024 оны 12 дугаар сарын байдлаар ажил олгогчдоос нийт **112,390** ажлын байрны захиалга ирүүлсэнээс **33,485** иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт **29,7** хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 686 хүнээр буюу 5,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




### **Ажилд зуучлагдсан иргэдийг байршил, хүйсээр харуулвал**

| № |                    | Бүгд         | Эмэгтэй      |
|---|--------------------|--------------|--------------|
|   | <b>Баруун бүс</b>  | <b>5,165</b> | <b>2,409</b> |
| 1 | Баян-Өлгий         | 792          | 301          |
| 2 | Говь-Алтай         | 1001         | 512          |
| 3 | Завхан             | 352          | 181          |
| 4 | Увс                | 1375         | 683          |
| 5 | Ховд               | 1645         | 732          |
|   | <b>Хангайн бүс</b> | <b>8,194</b> | <b>3,975</b> |

|    |                    |               |               |
|----|--------------------|---------------|---------------|
| 6  | Архангай           | 1561          | 596           |
| 7  | Баянхонгор         | 1932          | 1079          |
| 8  | Булган             | 1164          | 489           |
| 9  | Орхон              | 1191          | 764           |
| 10 | Өвөрхангай         | 779           | 382           |
| 11 | Хөвсгөл            | 1567          | 665           |
|    | <b>Төвийн бүс</b>  | <b>6,956</b>  | <b>3,532</b>  |
| 12 | Говьсүмбэр         | 342           | 205           |
| 13 | Дархан-Уул         | 1292          | 722           |
| 14 | Дорноговь          | 856           | 389           |
| 15 | Дундговь           | 1204          | 622           |
| 16 | Өмнөговь           | 958           | 385           |
| 17 | Сэлэнгэ            | 1523          | 791           |
| 18 | Төв                | 781           | 418           |
|    | <b>Зүүн бүс</b>    | <b>3,725</b>  | <b>1,660</b>  |
| 19 | Дорнод             | 1261          | 523           |
| 20 | Сүхбаатар          | 1094          | 511           |
| 21 | Хэнтий             | 1370          | 626           |
|    | <b>Улаанбаатар</b> | <b>9,445</b>  | <b>5,187</b>  |
| 1  | Хан-Уул            | 861           | 580           |
| 2  | Багануур           | 586           | 285           |
| 9  | Баянзүрх           | 1689          | 832           |
| 4  | Налайх             | 610           | 339           |
| 5  | Баянгол            | 675           | 392           |
| 6  | Сүхбаатар          | 501           | 292           |
| 7  | Чингэлтэй          | 861           | 501           |
| 8  | Багахангай         | 92            | 39            |
| 9  | Сонгинохайрхан     | 3570          | 1927          |
|    | <b>УЛСЫН ДҮН</b>   | <b>33,485</b> | <b>16,763</b> |

Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл:




Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлгээр авч үзвэл:

| Насны бүлэг | Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо | Үүнээс эмэгтэй | Эзлэх хувь |
|-------------|-------------------------------------|----------------|------------|
| 15-24       | 5,335                               | 2,491          | 15.9       |
| 25-34       | 9,252                               | 4,584          | 27.6       |
| 35-44       | 8,760                               | 4,496          | 26.2       |
| 45-54       | 6,240                               | 3,062          | 18.6       |
| 55-59       | 1,960                               | 1,014          | 5.9        |
| 60+         | 1,938                               | 1,116          | 5.8        |
| <b>ДҮН</b>  | <b>33,485</b>                       | <b>16,763</b>  | <b>100</b> |



Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг өмчийн хэлбэрээр авч үзвэл:

| Байгууллагын өмчийн хэлбэрээр | Ажилд орсон иргэдийн тоо: Бүгд | Үүнээс: Эмэгтэй | Эзлэх хувь   |
|-------------------------------|--------------------------------|-----------------|--------------|
| Төрийн өмчийн                 | 14,038                         | 7,698           | 41.9         |
| Орон нутгийн өмчийн           | 1,548                          | 626             | 4.6          |
| Хувийн өмчийн                 | 17,899                         | 8,439           | 53.5         |
| <b>ДҮН</b>                    | <b>33,485</b>                  | <b>16,763</b>   | <b>100.0</b> |



2.4 Ажлын шинэ байр

Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сард нийт **31882** ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна.

Ажлын шинэ байрны бүртгэлийг орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн ажлын байрны бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд Ажил олгогч байгууллагууд болон аж ахуйн нэгжтэй холбогдон хамтран бүртгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Тухайн нутаг дэвсгэр дээрх шинээр байгуулагдсан салбар нэгжүүд буюу шинээр бий болж байгаа ажлын байрыг бүртгэж мэдээллийг “Ejob” програмаар нэгтгэн гаргаж байна. Тайлант хугацаанд нийт **31882** ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл **4256** хүнээр буюу 11,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




**Шинэ ажлын байранд орсон иргэдийг байршил, хүйсээр харуулвал**  
Нийт шинэ ажлын байрнаас, байнгын шинэ ажлын байр 20876 буюу 65,5 хувь, улирлын шинэ ажлын байр 2064 буюу 6,5 хувь, түр шинэ ажлын байр 8942 буюу 28,0 хувийг тус тус эзэлж байна.

| №  | Аймаг, нийслэл | Бүгд | Эмэгтэй |
|----|----------------|------|---------|
|    | Баруун бүс     | 5791 | 2645    |
| 1  | Баян-Өлгий     | 518  | 244     |
| 2  | Говь-Алтай     | 1086 | 453     |
| 3  | Завхан         | 1345 | 606     |
| 4  | Увс            | 2181 | 1021    |
| 5  | Ховд           | 661  | 321     |
|    | Хангайн бүс    | 8208 | 3886    |
| 6  | Архангай       | 1764 | 644     |
| 7  | Баянхонгор     | 1684 | 881     |
| 8  | Булган         | 939  | 380     |
| 9  | Орхон          | 1104 | 748     |
| 10 | Өвөрхангай     | 1105 | 550     |
| 11 | Хөвсгөл        | 1612 | 683     |
|    | Төвийн бүс     | 6722 | 3555    |
| 12 | Говьсүмбэр     | 352  | 215     |
| 13 | Дархан-Уул     | 1901 | 1090    |
| 14 | Дорноговь      | 1158 | 567     |
| 15 | Дундговь       | 337  | 207     |

|    |                    |              |              |
|----|--------------------|--------------|--------------|
| 16 | Өмнөговь           | 542          | 309          |
| 17 | Сэлэнгэ            | 1124         | 553          |
| 18 | Төв                | 1308         | 614          |
|    | <b>Зүүн бүс</b>    | <b>3352</b>  | <b>1279</b>  |
| 19 | Дорнод             | 815          | 346          |
| 20 | Сүхбаатар          | 1249         | 465          |
| 21 | Хэнтий             | 1288         | 468          |
|    | <b>Улаанбаатар</b> | <b>7809</b>  | <b>3721</b>  |
| 1  | Хан-Уул            | 1966         | 1009         |
| 2  | Багануур           | 133          | 56           |
| 9  | Баянзүрх           | 1379         | 699          |
| 4  | Налайх             | 224          | 120          |
| 5  | Баянгол            | 1174         | 602          |
| 6  | Сүхбаатар          | 1195         | 539          |
| 7  | Чингэлтэй          | 951          | 290          |
| 8  | Багахангай         | 9            | 0            |
| 9  | Сонгинохайрхан     | 778          | 406          |
|    | <b>УЛСЫН ДҮН</b>   | <b>31882</b> | <b>15086</b> |

Ажлын шинэ байранд орсон иргэд



#### ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИЙН ТАЙЛАН:

Хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг 2024 оны жилийн эцсийн дүнгээр авч үзвэл:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн: 6793
- Бүлгийн зөвлөгөө өгсөн: 2014
- Ажилд зуучилсан хүний тоо: 681
- 3 сар тогтвортой ажилласан иргэн: 437
- 6 сар тогтвортой ажилласан иргэн: 369
- 12 сар тогтвортой ажилласан иргэн: 197

Нийт олгосон санхүүжилт: 812,787,510 төгрөг

## ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДЭМЖИХ САНГИЙН ЖИЖИГ ЗЭЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан” Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” –ийн дагуу 2024 онд Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн санхүүжилтээр 13,000,000,000 төгрөгийн эх үүсвэрийг Хаан болон Төрийн банканд байршуулан жижиг зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын байдлаар Аймаг дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нийт 1095 төслийн хүсэлтийг хүлээн авч, зээл олгож болох эсэхийг судлуулахаар банканд хүргүүлсэн байна.

Үүнээс банкны шаардлага хангасан 579 төсөлд 13,886,562,500 төгрөгийн зээлийг олгосон байна.

| №        | Аймаг,<br>дүүрэг | Банк дэмжин жижиг<br>зээл олгосон төслийн<br>тоо |                | Жижиг зээл олгосон мөнгөн дүн |               |
|----------|------------------|--------------------------------------------------|----------------|-------------------------------|---------------|
|          |                  | Хаан банк                                        | Төрийн<br>банк | Хаан банк                     | Төрийн банк   |
| 1        | Архангай         | 28                                               | 20             | 507,000,000                   | 490,000,000   |
| 2        | Баян-Өлгий       | 9                                                | 5              | 194,200,000                   | 119,000,000   |
| 3        | Баянхонгор       | 13                                               | 6              | 160,000,000                   | 180,000,000   |
| 4        | Булган           |                                                  | 11             |                               | 235,000,000   |
| 5        | Говь-Алтай       | 28                                               | 4              | 875,000,000                   | 147,412,500   |
| 6        | Говьсүмбэр       | 11                                               | 1              | 150,000,000                   | 10,000,000    |
| 7        | Дархан-Уул       | 33                                               | 17             | 605,600,000                   | 400,000,000   |
| 8        | Дорноговь        | 6                                                | 4              | 72,000,000                    | 120,000,000   |
| 9        | Дорнод           | 14                                               | 6              | 314,800,000                   | 150,000,000   |
| 10       | Дундговь         | 5                                                | 3              | 210,000,000                   | 83,000,000    |
| 11       | Завхан           | 3                                                | 8              | 59,950,000                    | 182,000,000   |
| 12       | Орхон            | 3                                                | 4              | 25,000,000                    | 116,200,000   |
| 13       | Өвөрхангай       | 24                                               | 2              | 705,000,000                   | 20,000,000    |
| 14       | Өмнөговь         | 2                                                | 13             | 17,500,000                    | 259,000,000   |
| 15       | Сүхбаатар        | 14                                               | 27             | 275,000,000                   | 558,000,000   |
| 16       | Сэлэнгэ          | 2                                                | 12             | 60,000,000                    | 247,500,000   |
| 17       | Төв              | 2                                                | 13             | 20,000,000                    | 355,000,000   |
| 18       | Увс              | 33                                               | 37             | 414,700,000                   | 642,300,000   |
| 19       | Ховд             | 11                                               | 21             | 145,500,000                   | 581,000,000   |
| 20       | Хөвсгөл          | 3                                                | 9              | 110,000,000                   | 248,280,000   |
| 21       | Хэнтий           | 7                                                | 12             | 102,000,000                   | 293,500,000   |
| 22       | Багануур         | 8                                                | 6              | 275,000,000                   | 163,800,000   |
| 23       | Багахангай       | -                                                | 2              | -                             | 95,000,000    |
| 24       | Баянгол          | 27                                               | 10             | 1,005,200,000                 | 382,200,000   |
| 25       | Баянзүрх         | 6                                                | 5              | 300,000,000                   | 232,000,000   |
| 26       | Сонгинохайрхан   | -                                                | 9              | -                             | 291,500,000   |
| 27       | Сүхбаатар        | 9                                                | 1              | 240,000,000                   | 50,000,000    |
| 28       | Хан-Уул          | 3                                                | 1              | 92,000,000                    | 50,000,000    |
| 29       | Чингэлтэй        | -                                                | 2              | -                             | 60,000,000    |
| 30       | Налайх           | -                                                | 4              | -                             | 189,420,000   |
| Нийт дүн |                  | 304                                              | 275            | 6,935,450,000                 | 6,951,112,500 |

## ТАВ.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийн хэрэгжүүлж байна.

| №           | ҮЗҮҮЛЭЛТ                                                               | 2024 ОНЫ<br>БАТЛАГДСАН ТӨСӨВ |                       | 2024 ОНЫ<br>ГҮЙЦЭТГЭЛ<br>/12 сар/ |                       | НИЙТ<br>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br>ХУВЬ |                     |
|-------------|------------------------------------------------------------------------|------------------------------|-----------------------|-----------------------------------|-----------------------|------------------------------|---------------------|
|             |                                                                        | ХҮН                          | ХӨРӨНГӨ               | ХҮН                               | ХӨРӨНГӨ               | /Хүний<br>тоогоор/           | /Мөнгөн<br>дүнгээр/ |
| 1           | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ                                  | 121112                       | 1,836,681,700         | 113504                            | 1,332,128,853         | 93.7                         | 72.5                |
| 2           | Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг үйл ажиллагаа                              | 31948                        | 2,377,660,000         | 23377                             | 1,407,745,480         | 73.2                         | 60.0                |
| 3           | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа                               | 6698                         | 52,678,765,500        | 7446                              | 49,203,030,253        | 111.2                        | 93.4                |
